

ХЭМЖЛИЙН ЭРГЭЛЗЭЭ ТООЦСОН БҮРТГЭЛ

Д/Д	Тооцсон огноо	Дээжийн нэр, код	Өргөтгөсөн эргэлзээний утга	Хэмжлийн эргэлзээг тооцсон хүний гарын үсэг	Хянасан хүний гарын үсэг

ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН БҮРТГЭЛ

Д/Д	Өөрчлөлтийн дугаар	Хуудасны дугаар	Өөрчлөлт оруулсан шалтгаан



ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ЖУРАМ

1. Зорилго

Энэхүү журмаар Барилгын материалын лабораторийн сорилтын үр дүнгийн үнэн бодит байдлыг хянах, үнэлэх үйл ажиллагааг зохицуулна.

2. Хамрах хүрээ

Энэхүү журам нь Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /ГХБХБГ/-ын Барилгын материалын лабораторийн үйл ажиллагаанд хамаарна.

3. Үүрэг хариуцлага

3.1. Лабораторийн эрхлэгч бөгөөд чанарын менежер нь дараах үүргийг хэрэгжүүлнэ:

- 3.1.1. Сорилтын үр дүнгийн үнэн бодит байдалд тогтмол хяналт тавьж ажиллах
- 3.1.2. Сорилтын үр дүнгийн үнэн бодит байдалд хяналт тавих төлөвлөгөөг боловсруулж, батлуулан, хэрэгжүүлэх, тайлагнах
- 3.1.3. Шинжээчийг лаборатори хоорондын харьцуулалт, ур чадварын сорилтод оролцуулах үйл ажиллагааг зохион байгуулах
- 3.1.4. Хяналт явуулсан өгөгдлийг лабораторийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, шалгах, сайжруулахад ашиглах

3.2. Лабораторийн шинжээч бөгөөд техникийн менежер нь дараах үүргийг хэрэгжүүлнэ:

- 3.2.1. Дотоод хяналтыг хэрэгжүүлэх, лаборатори хоорондын харьцуулалт, ур чадварын сорилтод оролцох, үр дүнд дүн шинжилгээ хийх
- 3.2.2. Хэмжлийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хоорондын шалгалт хийх, бүртгэл хөтлөх, хадгалах /Маягт 01,02/

4. Үйл ажиллагаа

4.1. Лаборатори нь сорилтын үр дүнгийн үнэн бодит байдалд дараах зарчмаар хяналт тавьж ажиллах ба төлөвлөгөөтэй байна. Төлөвлөгөөг 2 жилийн хугацаатайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөнө. Үүнд:

- Дотоод хяналт
- Лаборатори хоорондын харьцуулалтад оролцох
- Ур чадварын сорилтод оролцох

4.2. ГХБХБГ-ын дарга төлөвлөгөөг хянаж батлах ба хяналтыг лабораторийн эрхлэгч төлөвлөгөөний дагуу явуулж, түүнд дүн шинжилгээ хийж, тайлагнана.

4.3. Шалгалтаар үл тохирох ажил илэрсэн тохиолдолд лабораторийн эрхлэгч "Үл тохирох ажил илрэхэд авах арга хэмжээний журам"-ын дагуу шийдвэрлэнэ.

- 4.4. Дүн шинжилгээ хийсэн тайланг үндэслэн лабораторийн ажилтнуудыг мэргэшүүлэх чиглэлийн сургалтанд хамруулах, дотоод сургалтыг зохион байгуулах, тоног төхөөрөмжийг солих, шинэчлэх зэргээр үйл ажиллагааг шалгах, сайжруулахад ашиглана.

5. Дотоод хяналт

- 5.1. Лаборатори нь дотоод хяналтын төлөвлөгөөнд дараах үйл ажиллагааг багтаасан байна. Үүнд:
- сорилтын ба хэмжлийн тоног төхөөрөмжийн ажиллагааг шалгах
 - хэмжлийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хоорондын шалгалт хийх
 - ижил эсвэл өөр аргуудыг ашиглан сорилтыг давтан хийх
 - хадгалагдаж буй дээжид сорилтыг давтан хийх
 - үл мэдэгдэх дээжийн сорилт
 - лаборатори доторхи харьцуулалт
 - тайлагнасан үр дүнг хянах
- 5.2. Дотоод хяналтыг төлөвлөгөөний дагуу лабораторийн эрхлэгч зохион байгуулах ба хяналтын өгөгдөлд дүн шинжилгээ хийж лабораторийн үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах арга хэмжээг авч ажиллана.
- 5.3. Дотоод хяналтыг шинжээч үр нөлөөтэй хэрэгжүүлнэ.

6. Лаборатори хоорондын харьцуулалтад оролцох

- 6.1. Лабораторийн эрхлэгч нь лаборатори хоорондын харьцуулалтад оролцохдоо өөрийн лабораториос илүү туршлагатай, итгэмжлэгдсэн лабораторийг сонгон, зөвшилцөн төлөвлөгөө гаргана.
- 6.2. Төлөвлөгөөний дагуу лабораторийн шинжээч оролцох ба эрхлэгч үр дүнд дүн шинжилгээ хийнэ.
- 6.3. Лаборатори хоорондын харьцуулалтад жилд 1-ээс доошгүй удаа оролцоно.

7. Ур чадварын сорилтод оролцох

- 7.1. Эрх бүхий байгууллагаас зохион байгуулсан ур чадварын сорилтод оролцох, төлөвлөх үйл ажиллагааг лабораторийн эрхлэгч зохион байгуулна.
- 7.2. Ур чадварын сорилтод лабораторийн шинжээч оролцоно.

8. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах

- 8.1. Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа ГХБХБГ-ын даргын тушаалаар шийдвэрлэнэ.
- 8.2. Журамд орсон нэмэлт, өөрчлөлтийг лабораторийн эрхлэгч бүртгэнэ.
- /Маягт 03/

100
Маягт 01

ХАТААХ ШҮҮГЭЭНИЙ ТЕМПЕРАТУР ШАЛГАСАН БҮРТГЭЛ

№	Огноо	Шалгах температур								Шалгасан шинжээчийн нэр, гарын үсэг
		60°C	100°C	105°C	125°C	140°C	200°C	250°C	300°C	

Маягт 02

ЛАБОРАТОРИЙН ЖИНГ ШАЛГАСАН БҮРТГЭЛ

№	Огноо	Харьцуулсан хэмжилтийн хэмжээ, гр	Хэмжилтийн хязгаар	Шалгасан дүн, гр	Зөрүү, гр	Шалгасан шинжээчийн нэр, гарын үсэг

Маягт 03

ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН БҮРТГЭЛ

д/д	Өөрчлөлтийн дугаар	Хуудасны дугаар	Өөрчлөлт оруулсан шалтгаан



ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

1. Зорилго

Энэхүү журмаар Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /ГХБХБГ/-ын Барилгын материалын лабораторийн үйл ажиллагаатай холбоотой гомдлыг шийдвэрлэх үйл ажиллагааг зохицуулна.

2. Хамрах хүрээ

Энэхүү журам нь Барилгын материалын лабораторид ирсэн гомдолд хамаарна.

3. Үүрэг хариуцлага

3.1. Лабораторийн удирдлага буюу Газрын дарга нь дараах үүргийг хэрэгжүүлнэ:

- Лабораторийн үйл ажиллагаатай холбоотой гомдлыг шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих, заавар зөвлөгөөгөөр хангах
- Гомдол давтан гарахаас урьдчилан сэргийлэх сайжруулах арга хэмжээг авах
- Буруутай ажилтанд хариуцлага тооцох

3.2. Лабораторийн эрхлэгч нь дараах үүргийг хэрэгжүүлнэ:

- Хэрэглэгчээс ирүүлсэн гомдлыг судлан үзэж үнэлэх, шийдвэрлэх арга хэмжээг авах
- Илэрсэн үл тохирлыг залруулах, сайжруулах арга хэмжээг авах

4. Гомдол хүлээн авах

4.1. Лабораторийн үйл ажиллагаатай холбоотой хэрэглэгч болон бусад талуудаас ирсэн гомдлыг ГХБХБГ-ын өргөдөл, гомдол хариуцсан ажилтан албан ёсоор бичгээр хүлээн авч бүртгэн, ГХБХБГ-ын даргад танилцуулна.

4.2. Хэрэглэгч нь байршил хол бичгээр гаргаж өгөх боломжгүй тохиолдолд гомдол саналаа утсаар мэдээлж болох ба дараа нь бичгээр гаргана.

4.3. ГХБХБГ-ын дарга лабораторийн эрхлэгчид хэрэглэгчээс ирүүлсэн гомдлыг шилжүүлнэ.

4.4. Лабораторийн эрхлэгч нь ГХБХБГ-ын даргын шилжүүлсэн гомдлыг бүртгэнэ. /Маягт 01/

5. Гомдлыг судлан үзэх, шийдвэрлэх

- 102
- 5.1. Гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.
 - 5.2. Гомдлыг хянан шийдвэрлэхэд нэмэлт ажиллагаа хийх, ээдрээ төвөгтэй байдлаас хамааран шийдвэрлэх хугацааг Газрын даргын шийдвэрээр 30 хүртэл хоногоор сунгаж болно.
 - 5.3. Лабораторийн эрхлэгч гомдлыг судлан үзэж, гомдол бодитой эсэхийг нотлох мэдээллийг цуглуулан шалгаж баталгаажуулна.
 - 5.4. Гомдлыг шийдвэрлэх, барагдуулахын тулд дараах арга хэмжээг авна:
 - Гомдлын учир шалтгааныг тодорхойлж, авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажиллах
 - Сорилтын үр дүнгийн үнэн бодит байдалтай холбоотой тохиолдолд хадгалагдаж буй дээжид сорилт шинжилгээг хэрэглэгчийг байлцуулан дахин хийлгэх
 - Туршлага, ур чадвар сайтай, хэрэглэгчийн санал болгосон, итгэмжлэгдсэн лабораторид тухайн дээжид сорилт шинжилгээг хэрэглэгч болон манай лабораторийн төлөөлөгчийг байлцуулан хийлгэх
 - Ажилтнуудын ёс зүй, харилцаа, мэдлэг, ур чадвараас шалтгаалсан гомдол ирсэн тохиолдолд судлан Газрын даргын шийдвэрээр шаардлагатай арга хэмжээг авах
 - Бусад шаардлагатай арга хэмжээг авах
 - 5.5. Дахин гомдол гарахаас урьдчилан сэргийлж гарч болзошгүй үл тохирол, хугацааны хойшлолт зэргийг үйлчлүүлэгчид цаг алдалгүй мэдээлнэ.
 - 5.6. Гомдлын мөрөөр сэргийлэх, залруулах үйл ажиллагааг хэрэгжүүлж, холбогдох баримт бичгүүдийг хадгална.

6. Гомдлын хариуг хүргүүлэх

- 6.1. Лабораторийн эрхлэгч гомдлыг шийдвэрлэн Газрын даргад танилцуулна.
- 6.2. ГХБХБГазар нь гомдлын хариуг хэрэглэгчид албан ёсоор хүргүүлэх ба электрон шуудангаар явуулсан тохиолдолд бүртгэн баталгаажуулна.

7. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах

- 7.1. Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа ГХБХБГ-ын даргын тушаалаар шийдвэрлэнэ.
- 7.2. Журамд орсон нэмэлт, өөрчлөлтийг лабораторийн эрхлэгч бүртгэнэ.
/Маягт 02/

ГОМДЛЫН БҮРТГЭЛ

д/д	Гомдлын агуулга	Бүртгэсэн огноо	Гомдол гаргагчийн нэр	Хэрхэн барагдуулсан, хариуг өгсөн талаарх мэдээлэл

ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН БҮРТГЭЛ

д/д	Өөрчлөлтийн дугаар	Хуудасны дугаар	Өөрчлөлт оруулсан шалтгаан



ҮЛ ТОХИРОХ АЖИЛ ИЛРЭХЭД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖУРАМ

1. Зорилго

Энэхүү журмаар Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /ГХБХБГ/-ын Барилгын материалын лабораторийн ажил, түүний үр дүн нь хэрэглэгчтэй тохиролцсон шаардлагыг хангаагүй, лабораторийн бодлого журамд тохирохгүй үед хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулна.

2. Хамрах хүрээ

Энэхүү журам нь ГХБХБГ-ын Барилгын материалын лабораторийн үйл ажиллагаанд хамаарна.

3. Эрх, үүрэг, хариуцлага

3.1. ГХБХБГ-ын дарга нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

- 3.1.1. Лабораторийн эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг хянаж батлах, илэрсэн үл тохирох ажлыг төлөвлөгөөний дагуу арилгах, удирдлага зохион байгуулалтаар хангах
- 3.1.2. Илэрсэн үл тохирох ажлын учир шалтгаанд үндэслэн шаардлагатай арга хэмжээг авах, буруутай ажилтанд хариуцлага ногдуулах
- 3.1.3. Үл тохирох ажлыг арилгаж, залруулсны дараа ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгох

3.2. Лабораторийн эрхлэгч нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

- 3.2.1. Илэрсэн үл тохирох ажлын учир шалтгааныг судлан тогтоох үйл ажиллагааг зохион байгуулах
- 3.2.2. Үл тохирол гаргахгүйн тулд ажилтнуудын мэдлэг ур чадварыг сайжруулах, тоногт төхөөрөмжийн ашиглалт, шалгалт тохируулгыг хугацаанд нь хийлгэх, бүртгэлүүдэд хяналт тавих зэрэг шаардлагатай арга хэмжээг авч ажиллах
- 3.2.3. Залруулах ажиллагааг зохион байгуулах
- 3.2.4. Илэрсэн үл тохирлыг бүртгэлжүүлэх ба цаашид дахин үл тохирол гаргахгүй байх арга хэмжээг авч ажиллана. /Маягт 01/

4. Үйл ажиллагаа

- 4.1. Үл тохирох ажилд хэрэглэгчтэй тохиролцсон шаардлагыг хангаагүй, холбогдох стандартын шаардлага, лабораторийн бодлого, дүрэм, журамд нийцээгүй асуудлууд хамаарна.
- 4.2. Лабораторийн эрхлэгч илэрсэн үл тохирлыг бүртгэж, ГХБХБГ-ын даргад танилцуулна.

- 4.3. Лабораторийн үйл ажиллагаанд үл тохирол илрэхэд лабораторийн эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд үндэслэн лабораторийн эрхлэгч нь шаардлагатай тохиолдолд сорилтын ажлыг зогсоох, давтан хийлгэх, сорилтын тайланг олгохыг хойшлуулах зэрэг арга хэмжээг авна.
- 4.4. Лабораторийн ажилтнууд эхний ээлжинд илэрсэн үл тохирох ажлын учир шалтгааныг нарийн нягт нямбай судлан тогтоож, дүн шинжилгээ хийж арилгах арга хэмжээг авна.
- 4.5. Үл тохирох ажил илэрснийг зөвшөөрсөн шийдвэрийн хамт залруулах арга хэмжээг нэн даруй авна.
- 4.6. Шаардлагатай тохиолдолд хэрэглэгчид мэдэгдэж, сорилтын ажлыг хүчингүй болгоно.
- 4.7. Үл тохирох ажлыг залруулсны дараа ГХБХБГ-ын даргын зөвшөөрлөөр сорилтын ажлыг дахин эхлүүлнэ.
- 4.8. Лаборатори нь үл тохирох ажил, түүнтэй холбоотой авсан арга хэмжээний бүхий л баримт бичгүүдийг хадгална.
- 4.9. Эрх бүхий холбогдох байгууллагуудын үнэлгээ болон дотоод аудитаар үл тохирол дахин давтагдах нь тогтоогдсон, эсвэл лабораторийн үйл ажиллагаа нь өөрийн менежментийн тогтолцоотой нийцэхгүй байгаа эргэлзээ төрсөн талаар үнэлэлт дүгнэлт гарсан үед лабораторийн эрхлэгч нь залруулах арга хэмжээг авч ажиллана.

5. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах

- 5.1. Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа ГХБХБГ-ын даргын тушаалаар шийдвэрлэнэ.
- 5.2. Журамд орсон нэмэлт, өөрчлөлтийг лабораторийн эрхлэгч бүртгэнэ. /Маягт 02/

ҮЛ ТОХИРЛЫН БҮРТГЭЛ

№	Илэрсэн үл тохирлын товч утга	Бүртгэсэн огноо	Илрүүлсэн хүчин зүйл, нөхцөл шалтгаан	Бүртгэсэн ажилтны нэр, гарын үсэг

ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН БҮРТГЭЛ

№	Өөрчлөлтийн дугаар	Хуудасны дугаар	Өөрчлөлт оруулсан шалтгаан

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ЛАБОРАТОРИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Барилгын материалын лаборатори /цаашид Лаборатори гэх/-ийн сорилт шинжилгээ, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаатай холбоотой үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2. Энэхүү журмыг лабораторийн ажилтнууд дагаж мөрдөнө.

Хоёр. Ерөнхий шаардлага

- 2.1. Барилгын ажилд хэрэглэгдэх барилгын материал, түүхий эд, бүтээгдэхүүнийг хүлээн авч бүртгэх, сорилт шинжилгээ хийх, дүнг хянаж, баталгаажуулах, хэрэглэгчид хүлээлгэн өгөх бүх үйл ажиллагааг лабораторийн чанарын удирдлагын тогтолцооны баримт бичгийн дагуу хэрэгжүүлнэ.
- 2.2. Лабораторийн сорилт шинжилгээний өрөө тасалгаанд лабораторийн эрхлэгчийн зөвшөөрлөөр нэвтэрнэ.
- 2.3. Лабораторид сорилт шинжилгээ хийх сорилтын зүйлийн тоо ширхэг, хэмжээг хангасан байна. Энэхүү шаардлагын талаар лабораторийн мэдээллийн самбарт байршуулна.
- 2.4. Шинжээч нь бие даасан, хараат бус байдлаар стандартын дагуу сорилт, шинжилгээг хийж гүйцэтгэнэ.
- 2.5. Лабораторийн эрхлэгч буюу чанарын менежер нь чанарын удирдлагын тогтолцооны хэрэгжилтийг хангуулан холбогдох журмын дагуу дотоод аудит, менежментийн дүн шинжилгээг тухайн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэн ажиллана.
- 2.6. Лабораторийн эрхлэгч нь лабораторийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангуулан ажиллах ба бүх ажилтнууд мөрдөн ажиллана.
- 2.7. Лабораторийн эрхлэгч нь шинжээч нарт лабораторит мөрдөх дүрэм, чанарын гарын авлага, журмуудыг танилцуулж тухай бүрт нь бүртгэл хөтөлнө. /Маягт №1/

Гурав. Дээж хүлээн авах, бүртгэх

- 3.1. Эрхлэгч нь сорилтын зүйл /дээж/-ийг хүлээн авахаас өмнө сорилт шинжилгээ хийх шаардлагыг хангасан эсэхийг шалгаж хүлээн авна.
- 3.2. Шаардлага хангасан тохиолдолд эрхлэгч нь дээжийг хүлээн авч, дээж хүлээн авах бүртгэлд бүртгэн, дугаарлана.
- 3.3. Эрхлэгч нь хүлээн авсан дээжийг бусад дээжүүдтэй солигдохоос нь сэргийлэн уут савны гадна талд дугаарыг тод гаргацтай, арилахааргүй бичиж тэмдэглэх зэрэг шаардлагатай тэмдэг тэмдэглэгээг хийнэ.
- 3.4. Эрхлэгч нь хүлээн авсан дээжийг шинжилгээнд хамрагдах дээжийн бүртгэлд бүртгэн, шинжээчид хүлээлгэн өгнө.

Дөрөв. Сорилт шинжилгээ хийх

- 4.1. Шинжээч нь дээжийг хүлээн авч стандартын дагуу сорилт шинжилгээг эхлүүлж, шинжилгээний тоо мэдээлэл, огноо зэргийг дугаарлалт бүхий шинжилгээний дэвтэрт тэмдэглэн, үр дүнг тооцон, гарын үсэг зурж баталгаажуулан лабораторийн эрхлэгчид танилцуулан хянуулна.
- 4.2. Анхан шатны баримт болох шинжилгээний дэвтрийн хуудас дутаах, гэмтээх, бичсэн зүйлийг баллахыг хориглоно.
- 4.3. Лабораторийн эрхлэгч шинжилгээний үйл явц, үр дүнг хянаж баталгаажуулна.
- 4.4. Шинжээчийн гаргасан сорилтын дүнг эрхлэгч хянаж, шинжилгээний төлбөр хийгдсэн эсэхийг нягталсны дараа дугаарлалт бүхий хэвлэмэл хуудас дээр 2 хувь сорилтын тайланг хэвлэн лабораторийн эрхлэгч, шинжээч нар гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна.
- 4.5. Сорилтын тайлангийн 1 хувийг хэрэглэгчид хүлээлгэн өгч, лаборатори 1 хувийг цахим болон цаасан хэлбэрээр хадгална.
- 4.6. Эрхлэгч нь сорилтын тайланг хэрэглэгчид хүлээлгэн өгсөн бүртгэлийг хөтөлнө. /Маягт №2/
- 4.7. Сорилт шинжилгээ дууссаны дараа шинжээч нь дээжийг тэмдэглэн, дээж хадгалах өрөөнд эмх цэгцтэй байрлуулан хадгална.

Тав. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа

- 5.1 Лабораторийн ажилтнууд нь лабораторийн үйл ажиллагаанд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны стандарт, дүрэм, зааварчилгааг чанд мөрдөнө.
- 5.2 Лабораторийн эрхлэгч хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг боловсруулан мөрдүүлж ажиллана.
- 5.3 Лабораторийн үйл ажиллагааны ерөнхий зарчим, ажлын байр, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй ажиллах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хэрхэн хангаж ажиллах талаар шинжээч нарт тухайн өдөрт гүйцэтгэх сорилт шинжилгээний нэр төрлөөс нь хамааруулан зааварчилгааг лабораторийн эрхлэгч өгч, гарын үсэг зуруулан Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дэвтэрт бүртгэж баталгаажуулна.

- 5.4 Шинээр ажилд орж буй ажилтанд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа болон сорилт шинжилгээнд ашиглах тоног төхөөрөмж, багаж хэрэгслэлийн ашиглалт, аюулгүй ажиллагааны зааварчилгааг бүрэн гүйцэт танилцуулж, тухай бүрт нь бүртгэж баталгаажуулна. /Маягт №3/
- 5.5 Лабораторийн сорилт шинжилгээний өрөө тасалгаанд зөвшөөрөлгүй гадны хүн, хүүхэд оруулах, тоног төхөөрөмж дээр ажиллуулахыг хориглоно.
- 5.6 Тоног төхөөрөмж, багаж хэрэгслэлийн аюулгүй, хэвийн үйл ажиллагаанд эзэмшигчид, ажиллагсад нь байнга хяналт тавьж, гэмтэл согог гарсан тухай бүрд нь эрхлэгчид мэдэгдэж, засварлуулах арга хэмжээг авна.
- 5.7 Аливаа тоног төхөөрөмж, багаж хэрэгслэлийг ажиллуулахын өмнө бүрэн бүтэн байдал, цахилгааны холболтын утасны гэмтэл, ажиллагаанд хүндрэл учруулж болзошгүй зүйл байгаа эсэхийг нарийвчлан шалгана.
- 5.8 Тоног төхөөрөмжийг унтраах, асаах үйлдлүүдийг гадны хүнээр гүйцэтгүүлэхийг хориглоно. Цахилгааны тоноглолыг нойтон гараар асаах, унтраах болон мэдэхгүй зүйлийг өөрөө дур мэдэн засварлахыг хориглоно.
Тоног төхөөрөмжүүдэд газардуулга хийсэн байна. Тоног төхөөрөмж, багаж хэрэгслэлийн засвар, үйлчилгээг мэргэжлийн хүнээр хийлгэх ба энэ үед хүчдэлээс заавал салгаж энэ талаар дохио санамж тавьсан байна.
- 5.9 Ажлын байрны эмх цэгц, зохион байгуулалт, гэрэлтүүлгийг ямагт зохих хэмжээнд байлгаж, ажлын байрыг эзэнгүй орхих, тоног төхөөрөмжүүдийг хараа хяналтгүй ажиллуулахыг хориглоно.
- 5.10 Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл хэрэглэн ажил гүйцэтгэнэ. Ажил дуусмагц ажлын байрыг цэвэрлэж цахилгааны төхөөрөмжийг хүчдэлээс салгана.
- 5.11 Прессийг ажиллуулахдаа шинжээчийг хамгаалах зорилгоор хаалтыг хэрэглэх, зөвшөөрөлтэйгээр нэвтэрсэн хүнийг улаан шугамнаас цааш зогсоох зэрэг шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.
- 5.12 Сорилт шинжилгээ хийж байгаа үед орчин нөхцөл, тоног төхөөрөмжийн байршил, тохиргоонд өөрчлөлт оруулж болохгүй.
- 5.13 Түүхий эд материалыг бутлах, шигших үед ойж үсрэхээс хамгаалж хаалт, нүдний шил зүүх ба тоосролтоос хамгаалж амны хаалт, хошуувч хэрэглэнэ.
- 5.14 Зуурагчаар хольц, зуурмаг зуурах, хутгаж холих үед хольцоос гараар авахыг оролдох, сэлүүрт гар хүрэх, орооцолдох аливаа боломж гаргахыг хориглоно.
- 5.15 Сорьцыг доргиулж хэвлэх, нягтруулах үед биенд шууд доргилт өгөхөөс хамгаалах хэрэгслэлийг хэрэглэнэ.
- 5.16 Сорьц дээжийг хатаах зорилгоор өндөр температурт ашиглаж байгаа тоног төхөөрөмжийг онгойлгох, дотор нь байгаа дээжинд гар хүрэхийг хориглоно. Сорьцыг төхөөрөмжинд байрлуулах, гаргахдаа цахилгааны хүчдэлийг салгасан байх ба заавал бээлий өмсөнө.
- 5.17 Дуу шуугиан ихтэй туршилтын үед чихэвч хэрэглэх ба гадны хүн орохыг хориглоно.
- 5.18 Химийн хортой бодистой ажиллаж байгаа үед бээлий, хормогч, нүдний шил зэрэг хамгаалах хэрэгслийг заавал хэрэглэнэ.

Зургаа. Хориглох зүйл

- 111
- 6.1 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг зөрчих, хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгслэлийг бүрэн хэрэглэхгүй байх, тоног төхөөрөмжийн ашиглалтын зааварчилгааг зөрчих.
- 6.2 Сорилт шинжилгээг гүйцэтгэх явцдаа анхаарал сарниулах үйлдэл хийх /утсаар ярих, дуу хөгжим сонсох, бусадтай ярилцах гэх мэт/
- 6.3 Лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслэлийг эрхлэгчийн зөвшөөрөлгүйгээр ажлын байрнаас гаргах.
- 6.4 Сорилт шинжилгээний дүн эцэслэн гараагүй байхад хэрэглэгч, харилцагчид албан бусаар мэдэгдэх.

---000---

Маягт №1

Лабораторийн бодлогын бичиг баримтуудыг танилцсан бүртгэл

Д/д	Баримт бичгийн нэр	Танилцуулсан огноо	Танилцуулсан хүний гарын үсэг	Танилцсан хүний гарын үсэг

Маягт №2


Сорилтын тайланг хүлээлгэн өгсөн бүртгэл

Д/д	Компанийн нэр	Тайлангийн дугаар	Хүлээлгэн өгсөн огноо

Маягт №3

Тоног төхөөрөмжийг ажиллуулах заавар, аюулгүй ажиллагааг хангаж ажиллах зааварчилгааг ажилчдад танилцуулсан бүртгэл

Д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Зааварчилгаа өгсөн огноо	Зааварчилгаа өгсөн хүний гарын үсэг	Зааварчилгаа авсан хүний гарын үсэг



ДОТООД АУДИТ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Зорилго

Дотоод аудитын зорилго нь Барилгын материалын лаборатори /цаашид лаборатори гэх/-ийн үйл ажиллагаа нь менежментийн тогтолцооны шаардлагад үргэлжлэн нийцэж байгааг батлах, чанарын гарын авлага болон холбогдох баримт бичигт дурьдсан шаардлагуудыг үр дүнтэй хэрэгжүүлж, хадгалж байгааг тогтооход оршино.

Хоёр. Төлөвлөх

- 2.1. Лабораторийн эрхлэгч нь дотоод аудитын хөтөлбөрийг 2 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр боловсруулж байгууллагын даргын тушаалаар батлуулж, хэрэгжүүлэн ажиллана.
- 2.2. Дотоод аудитыг жилд 1 удаа лабораторийн эрхлэгч хариуцан зохион байгуулна.
- 2.3. Менежментийн тогтолцооны бүх элементүүд жилд 1 удаа шалгагдаж байхаар дотоод аудитыг төлөвлөнө.
- 2.4. Дотоод аудитын хөтөлбөрийн дагуу тухайн жилийн дотоод аудитын удирдамж, шалгах хуудсыг боловсруулан байгууллагын даргын тушаалаар батлуулна.
- 2.5. Шалгах хуудсыг боловсруулахдаа шалгуур үзүүлэлт, хамрах хүрээг тодорхойлж, зохицуулагч байгууллагын шаардлага, стандартын шаардлага, лабораторийн бодлого, дүрэм журмын шаардлагуудаас тусгана.
- 2.6. Дотоод аудитыг ажлын хэсгээр болон лабораторийн эрхлэгч буюу чанарын менежер ганцаараа явуулж болно.
- 2.7. Дотоод аудитыг ажлын хэсэг хийх тохиолдолд байгууллагын даргын тушаалаар тус ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилно.
- 2.8. Дотоод аудит хийх ажлын хэсгийн ахлагчаар лабораторийн үйл ажиллагаа болон чанарын удирдлагын тогтолцооны талаар зохих мэдлэгтэй, холбогдох сургалтанд хамрагдсан албан тушаалтныг томилж, ажиллуулна.
- 2.9. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд чанарын менежер орж ажиллаж болно.

Гурав. Дотоод аудитыг явуулах

- 3.1. Дотоод аудитыг явуулахдаа зохих хурлын тэмдэглэлүүдийг үйлдэнэ. Үүнд: Нээлт, хаалтын хурлын тэмдэглэлүүд

3.2. Нээлтийн хурал дээр аудитын удирдамж, аудит явуулах албан тушаалтан, ажлын хэсгийг танилцуулах, аудитын шалгуур үзүүлэлт, дүрэм журмыг тайлбарлах, бусад зүйлсийг тодруулна.

3.3. Дотоод аудитыг батлагдсан удирдамжийн дагуу "Шалгах хуудас"-аар үнэлнэ.

3.4. Аудитор нь менежментийн тогтолцооны баримт бичгүүд (Чанарын гарын авлага, журмууд, САЗ-ууд г.м)-ийг лавлагаа байдлаар ашиглан хэрэгжилтийг шалгана.

3.5. Аудитыг лабораторийн үйл ажиллагаанд саад учруулахгүйгээр явуулна.

3.6. Аудитор нь үл тохирлуудыг тэмдэглэж анхаарах асуудлыг тодорхойлохын тулд цаашид үл тохирлуудыг судлах хэрэгтэй.

3.7. Дотоод аудит явуулж дууссаны дараа аль нь үл тохиролд орох, аль нь сайжруулах үйл ажиллагааны зөвлөмжид орох талаар нарийвчилсан дүн шинжилгээ хийж, товч тодорхой аудитын тайланг гаргана.

3.8. Дотоод аудитын хаалтын хурлыг лабораторийн ажилтнууд болон байгууллагын удирдлагыг хамруулан хийж, аудитаар илрүүлсэн зүйлүүд, үйл ажиллагааны давуу болон сул талуудыг танилцуулна.

3.9. Аудитыг дууссаны дараа холбогдох мэдээллүүдийг агуулсан аудитын үр дүнг нэгтгэн дүгнэсэн эцсийн тайланг бичнэ.

3.10. Байгууллагын удирдлага дотоод аудитын тайлан, санал дүгнэлттэй танилцаж, шаардлагатай тохиолдолд тодорхой асуудлаар менежментийн дүн шинжилгээний хурлаар хэлэлцүүлэхээр оруулж болно.

3.11. Дотоод аудитаар илэрсэн үл тохирол нь лабораторийн үйл ажиллагааг сайжруулах үйл явцад чухал мэдээлэл болох бөгөөд менежментийн дүн шинжилгээний оролт байдлаар ашиглаж болно.

Дөрөв. Илэрсэн үл тохирлыг залруулах

4.1. Лабораторийн эрхлэгч нь үл тохирлыг бүртгэн, залруулах арга хэмжээг авч, тайлагнана.

4.2. Залруулах арга хэмжээг аль болох богино хугацаанд хийж хэрэгжүүлнэ.

4.3. Сорилт шинжилгээ, хяналтын үр дүнд маш ихээр нөлөөлж болох үл тохирол илэрсэн тохиолдолд тухайн тоног төхөөрөмж, сорилт шинжилгээг түр зогсоож, залруулах арга хэмжээг авч ажиллана.

4.4. Лабораторийн эрхлэгч нь аудитаар илэрсэн үл тохирол, залруулах ажиллагааг бүртгэнэ. /Маягт-1, 2/

Тав. Бусад

5.1. Лабораторийн эрхлэгч нь дотоод аудитыг бүртгэнэ. /Маягт- 3/

5.2. Аудитаар үл тохирол илрээгүй тохиолдолд ч дотоод аудитын тэмдэглэлийг бүрэн хөтөлсөн байна.

5.3. Аудит хийсэн баримт бичгүүдийг хадгална.

5.4. Хууль тогтоомж, байгууллагын дүрмийн өөрчлөлт, зайлшгүй хэрэгцээ шаардлага зэргийг үндэслэн тус журамд оруулах нэмэлт, өөрчлөлтийг байгууллагын даргын тушаалаар шийдвэрлэнэ. /Маягт-4/

---000---

Маягт -01

ҮЛ ТОХИРЛЫН БҮРТГЭЛ

№	Илэрсэн үл тохирлын товч утга	Бүртгэсэн огноо	Илрүүлсэн хүчин зүйл, нөхцөл шалтгаан	Бүртгэсэн ажилтны нэр, гарын үсэг

Маягт - 2

ЗАЛРУУЛАХ АЖИЛЛАГААНЫ БҮРТГЭЛ

№	Илэрсэн үл тохирлын товч утга	Залруулсан огноо	Бүртгэсэн ажилтны нэр, гарын үсэг

Маягт - 3

ДОТООД АУДИТЫН БҮРТГЭЛ

№	Бүртгэсэн огноо	Илрүүлсэн зөрчил	Бүртгэсэн ажилтны нэр, гарын үсэг

Маягт 04

ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН БҮРТГЭЛ

№	Өөрчлөлтийн дугаар	Хуудасны дугаар	Өөрчлөлт оруулсан шалтгаан

МЕНЕЖМЕНТИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Зорилго

Менежментийн дүн шинжилгээний зорилго нь Барилгын материалын лаборатори /цаашид лаборатори гэх/-ийн үйл ажиллагааг сайжруулах, менежментийн тогтолцооны үргэлжлэн тохирох байдал, үр дүнтэй байдлыг хангуулахад оршино.

Хоёр. Хамрах хүрээ

Энэхүү журам нь лабораторийн үйл ажиллагаанд хамаарна.

Гурав. Менежментийн дүн шинжилгээг хийх

- 3.1. Байгууллагын удирдлага лабораторийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор менежментийн дүн шинжилгээг жилд 1 удаа зохион байгуулна.
- 3.2. Менежментийн дүн шинжилгээ хийх бүрэлдэхүүнд лабораторийн эрхлэгч, шинжээч, холбогдох хэлтсийн дарга, мэргэжилтэн, нягтлан бодогч, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн зэрэг албан тушаалтнууд орох бөгөөд лабораторийн эрхлэгч хариуцан зохион байгуулна.
- 2.1. Лабораторийн эрхлэгч менежментийн дүн шинжилгээний оролтыг бүртгэн хэлэлцүүлэх ба оролтод лабораторийн тухайн жилийн төлөвлөгөөний биелэлт, лабораторид хамааралтай дотоод, гадаад орчны өөрчлөлт, зорилтын биелэлт, Чанарын гарын авлага, журмын нийцтэй байдал, менежментийн дүн шинжилгээ хийхээс өмнөх ажиллагааны үр дүн, дотоод аудитын үр дүн, залруулах ажиллагаа, гадны байгууллагаас хийсэн үнэлгээ, ажлын тоо хэмжээ, төрөл эсвэл лабораторийн үйл ажиллагааны хүрээнд гарсан өөрчлөлт, хэрэглэгч ба ажилтнуудын санал хүсэлт, гомдол, хэрэгжүүлсэн сайжруулах ажиллагааны үр дүнтэй байдал, нөөцийн хүртээмжтэй байдал, эрсдэлийг тодорхойлсон үр дүн, үр дүнгийн үнэн бодит байдлыг нотолсон дүн, хяналтын үйл ажиллагаа, сургалт, бусад хүчин зүйлс орно.
- 2.2. Менежментийн дүн шинжилгээний шийдвэр нь хурлын тэмдэглэл хэлбэртэй байх ба шийдвэрийг лабораторийн ирэх жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

- 2.3. Менежементийн дүн шинжилгээний шийдвэрт лабораторийн үйл ажиллагааг сайжруулах, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, өөрчлөлтийн хэрэгцээ зэрэгтэй холбоотой асуудлуудыг тусгасан байна.
- 2.4. Менежментийн дүн шинжилгээний бүртгэлийг лабораторийн эрхлэгч хөтөлнө.
/Маягт - 1/

Дөрөв. Бусад

- 3.1. Хууль тогтоомж, байгууллагын дүрмийн өөрчлөлт, зайлшгүй хэрэгцээ шаардлага зэргийг үндэслэн тус журамд оруулах нэмэлт, өөрчлөлтийг байгууллагын даргын тушаалаар шийдвэрлэнэ.

---000---

Маягт - 1

МЕНЕЖМЕНТИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ БҮРТГЭЛ

№	Бүртгэсэн огноо	Хэлэлцсэн гол асуудлууд	Бүртгэсэн ажилтны нэр, гарын үсэг



БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН ЖУРАМ

1. Зорилго

Энэхүү журмаар Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /ГХБХБГ/-ын Барилгын материалын лабораторийн менежментийн тогтолцоог хангаж байгааг нотлох бүртгэлүүдийг хөтөлж, хадгалахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулна.

2. Хамрах хүрээ

Энэхүү журам нь ГХБХБГ-ын Барилгын материалын лабораторийн ажилтнуудад хамаарна.

3. Нийтлэг үндэслэл

- 3.1 Баримт бичигт тавигдах шаардлагыг хангаж байгааг нотлохын тулд тэмдэглэлийг гаргац, үнэн зөв хөтөлж, архивлан хадгална.
- 3.2 Лаборатори нь бүртгэлийг он тус бүрээр нь архивлах ба бүртгэлтэй танилцах тохиолдолд нууцыг хадгалах үүрэг хүлээнэ.

4. Үүрэг хариуцлага

4.1. ГХБХБГ-ын лабораторийн эрхлэгч нь дараах асуудлыг хариуцна:

- 4.1.1. Баримт бичгийн нэгдсэн жагсаалт буюу мастер хуудсыг гаргаж, жагсаалтын дагуу бүртгэл тус бүрийн хөтлөлтөнд хяналт тавих. /Маягт №1/
- 4.1.2. Лабораторийн чанарын хяналтын бүртгэл хөтлөх ба шинжээчийн өдөр тутмын техникийн хяналтын бүртгэлд хяналт тавина.
- 4.1.3. Тоног төхөөрөмжүүдийг засварлах, шалгалт тохируулга хийлгэх бүрт тухайн тоног төхөөрөмжийн паспортад тэмдэглэх.
- 4.1.4. Лабораторийн журмуудын маягтын дагуу бүртгэлийг хөтлөх, хөтлөх явцад нь хяналт тавьж ажиллах

4.2 Лабораторийн шинжээч нар нь дараах асуудлыг хариуцна:

- 4.2.1 Сорилт, шинжилгээг хийх бүрт шаардлагатай техникийн бүртгэлүүдийг цаг тухайд тогтмол хөтлөх.
- 4.2.2 Анхан шатны бүртгэлүүдийг эмх цэгцтэй хөтлөж, дугаарлах, холбогдох тоног төхөөрөмжөөс гарах баримтуудыг баталгаажуулж хамтад нь архивлах
- 4.2.3 Тоног төхөөрөмжийг ашиглах бүртээ бүртгэл хөтөлж, үйл ажиллагаанд хяналт тавих, хэвийн бус тохиолдолд яаралтай лабораторийн эрхлэгчид мэдэгдэх.

---000---

Маягт №1

Баримт бичгийн нэгдсэн жагсаалт

Д/д	Баримт бичгийн нэр	Дугаар	Хэвлэгдсэн огноо	Хэвлэгдсэн огноо	Түгээлт	Өөрчлөлт оруулсан огноо	Байршил

---000---

ШУДРАГА БАЙДАЛ, НУУЦЫГ ХАДГАЛАХ ЖУРАМ

1. Зорилго

Энэхүү журмаар Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /ГХБХБГ/-ын Барилгын материалын лабораторийн ажиллагсадын /цаашид ажилтан гэх/ ёс зүй, шудрага байдал, сорилт шинжилгээний үр дүнтэй холбоотой мэдээллийг хэрхэн нууцлах талаарх үйл ажиллагааг зохицуулна.

2. Хамрах хүрээ

Энэхүү журам нь ГХБХБГ-ын Барилгын материалын лабораторийн ажилтнуудад хамаарна.

3. Нийтлэг үндэслэл

- 3.1 ГХБХБГ-ын дарга болон лабораторийн эрхлэгч, шинжээч нар нь шудрага байдлын мэдэгдэл гаргаж нийтэд ил харагдах газарт байрлуулан мөрдлөг болгож ажиллана.
- 3.2 Лабораторит ажиллагсад нь Төрийн албан хаагчийн ёс зүйг чанд мөрдөж ажиллах ба адил тэгш, хараат бус, бие даасан байдлаар үйл ажиллагаа явуулна.

4. Үүрэг хариуцлага

4.1. ГХБХБГ-ын лабораторийн эрхлэгч нь дараах асуудлыг хариуцна:

- 4.1.1. Ажилтнуудад сорилт шинжилгээг гадны нөлөөлөлд автахааргүйгээр гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлэх
- 4.1.2. Захиалагчийн ирүүлсэн дээжийг кодлож, архивлан хадгалах
- 4.1.3. Сорилтын тайланг зөвхөн захиалагчид хүлээлгэн өгч бүртгэл хөтлөнө.
- 4.1.4. Тухайн шинжилгээний үр дүнтэй холбоотой мэдээллийг өөр бусад хуулийн этгээдүүдэд задруулахгүй байх.

4.2 Лабораторийн шинжээч нар нь дараах асуудлыг хариуцна:

- 4.2.1 Сорилт, шинжилгээний үр дүнг зөвхөн лабораторийн эрхлэгчид тайлагнана.

- 4.2.2 Тухайн дээжинд сорилт, шинжилгээ хийх явцад олж авсан мэдээллээ чандлан хадгалах ба шаардлагатай тохиолдолд захиалагч, захиалагчийн хяналтаас өөр бусад хөндлөнгийн хуулийн этгээдийг байлцуулахгүйгээр сорилт шинжилгээг гүйцэтгэж болно.
- 4.2.3 Сорилтын дээж болон үр дүн зэрэг тухайн сорилт, шинжилгээтэй холбоотой олж авсан мэдээллийг гадагш нь задруулахгүй байх.

**5. Лабораторийн ажилтны шударга байдалд нөлөөлж
болзошгүй эрсдэл, авах арга хэмжээ**

д/д	Эрсдэл	Шийдвэрлэх арга хэмжээ
1	Дээд шатны удирдлагын нөлөөлөл	- Чанарын гарын авлага, Лабораторийн дүрэмд хараат бус, бие даасан байдлаар ажиллах талаар тодорхой тусгасан. - Лабораторийн ажилтнуудад нөлөөлөхгүй байх талаар "Шударга байдлын мэдэгдэл"-ийг байгууллагын дарга, лабораторийн эрхлэгч нар гаргаж баталгаажуулсан.
2	Ах дүү, найз нөхдийн нөлөөлөл	- Лабораторийн ажилтнууд нь шударга, хувийн ашиг сонирхолгүй ажиллах талаар "Шударга байдлын мэдэгдэл"-ийг гаргаж, баталгаажуулсан. - Төрийн албан хаагчийн ёс зүйг чанд мөрдөж ажиллана.
3	Хувийн ашиг сонирхол, санхүүгийн тусламж дэмжлэг авах	- Лабораторийн ажилтнууд нь шударга, хувийн ашиг сонирхолгүй ажиллах талаар "Шударга байдлын мэдэгдэл"-ийг гаргаж, баталгаажуулсан. - Төрийн албан хаагчийн ёс зүйг чанд мөрдөж ажиллана.



ДӨРНОГСЭЖ, АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
 ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
 ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 4/59

Дорноговь айбаг, Сайшанд цүн

Лабораторийн шинжилгээний үнэ, хэвлэмэл
 хуудас, дардасны загвар батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын 2014 оны 308 дугаар тогтоолоор батлагдсан "Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэх хөтөлбөр", "Зураг төсөл, эрдэм шинжилгээний институт", УТҮГ-ын захирлын 71 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын дэргэдэх Барилгын материалын сорилт, шинжилгээний лабораториос иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх үйлчилгээний төлбөр тарифыг нэгдүгээр хавсралтаар, Сорилт шинжилгээний үр дүнг баталгаажуулах албан бичгийн хэвлэмэл хуудсыг хоёрдугаар хавсралтаар, Лабораторийн дардасны загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх загваруудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Барилгын материалын үйлдвэрлэл, лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн / Ш.Найдансүрэн/-д даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан ГХБХБГ-ын даргын 2016 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/18 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
 ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЭНХБАТ

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын
даргын 2020 оны 09 дүгээр сарын 01-өдрийн
1159 дугаар тушаалын 4-р хавсралт



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ЛАБОРАТОРИТ МӨРДӨХ
ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНЭ ТАРИФ**

Д/д	Дээжийн нэр, төрөл		Дээжийн хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Элс		30 кг	48800	48800
2	Дайрга, хайрга		30 кг	60200	60200
3	Автоклавын бус сийрмэг бетон гулдмай		1 ш	54000	54000
4	Автоклавын хийт бетон гулдмай		1 ш	54000	54000
5	Бетон шоо	10x10 см	3 ш	2400	7200
		15x15 см	3 ш	3200	9600
6	Керамик тоосго	Нүхтэй	15 ш	42000	42000
		Өнгөлгөө		49800	49800
		Цул			
7	Хөөсөн полистрол хавтан		100x100 см	20000	20000
8	Явган зам, талбайн хавтан		15 ш	30200	30200
9	Цемент		20 кг	51300	51300

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын
даргын 2020 оны 12 дүгээр сарын 21-өдрийн
1/39 дугаар тушаалын 2-р хавсралт



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР
БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ЛАБОРАТОРИ**

СОРИЛТЫН ТАЙЛАН

оны -р сарын -ны өдөр

№.....

Код –

Захиалагч байгууллагын нэр	
Дээж хүлээн авсан огноо	
Дээжийн нэр, тоо хэмжээ	
Шинжилгээ хийж эхэлсэн, дууссан огноо	
Шинжилгээнд мөрдсөн стандарт	
Объектын хаяг	
Орд газар	
Хуудасны тоо, нийт/тухайн	

д/д	Шинжилгээний үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Байвал зохих	Үзүүлэлтийн утга

Шинжилгээний дүнг олшруулан хэрэглэх, хувилахыг хориглоно.
Шинжилгээний дүн нь захиалагчаас ирүүлсэн зөвхөн энэ дээжинд хүчинтэй.

Дорноговь аймаг, Сайншанд сум, 3-р баг, ГХБХБГ-ын албан байр Утас:7052-3978, Факс:7052-3998

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын
даргын 2020 оны 09 дүгээр сарын 01-өдрийн
А/59 дугаар тушаалын 3.-р хавсралт



Лабораторийн дардасны загвар

Тус газрын Барилгын материалын лаборатори нь "Итгэмжлэлийн гэрчилгээ"-ний хугацаа дууссан тохиолдолд итгэмжлэлийн тамга болон лого зэргийг шинжилгээний сорилтын тайланд хэрэглэхийг хориглоно.

Энэ хугацаанд байгууллагын тэмдэгийг хэрэглэнэ.





ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 760

Дорноговь аймаг, Сайншанд сум

Хүндэтгэл үзүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 14.6 дахь заалтыг тус тус үндэслэн **ТУШААХ** нь:

1. Ахмадын баярын өдрийг тохиолдуулан байгууллагаас тэтгэвэрт гарсан ахмад настнуудад хүндэтгэл үзүүлсүгэй.
2. Хүндэтгэл үзүүлэх ахмадын нэрсийг хавсралтаар баталсугай.
3. Дээрх арга хэмжээнд шаардагдах 900000 /есөн зуун мянган/ төгрөгийг Ахмадын сангаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЭНХБАТ

Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын
газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 17-ний
өдрийн 1/60 дугаар тушаалын хавсралт

ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ АХМАДЫН НЭРС, ЗАРДЛЫН ТООЦОО

№	Овог нэр	Алтан тушаал	Регистрийн дугаар	Мөнгөн дүн
1	С.Мөнхцэцэг	Ахмад настан	ЕЮ59041408	200,000
2	Г.Лхамсүрэн	Ахмад настан	ЕЕ50041613	200,000
3	Х.Оюунчимэг	Ахмад настан	ЕС60050201	200,000
4	Ч.Дүгэрсүрэн	Ахмад настан	ЕЮ53031511	200,000
5	Гарын бэлэг			100,000
	Нийт			900,000

---oOo---



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 11/61

Дорноговь аймаг, Сэлэнгэ сум

Эцэг эхийн зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 18 дугаар 18.1.5 дахь заалт, Хүүхдийн үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын эцэг, эхийн зөвлөлийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	Албан хэрэг хөтлөлт, архивын асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Ерөнхий нягтлан бодогч Барилгын материалын үйлдвэрлэл, лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн Лабораторийн шинжээч Нярав

2. Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах, байгууллагын албан хаагчдын хүүхдүүдийн авъяас чадварыг хөгжүүлэх, боловсрол эзэмших, нийгэмших, хүмүүжүүлэхэд нь эцэг, эх, багш нартай хамтран ажиллахыг зөвлөлийн дарга, гишүүдэд даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан ГХБХБГ-ын даргын 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/07 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЭНХБАТ



ДОРНОГОВЬ-АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭЖ ЖҮҮЛЭХЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
 ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
 ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/62

Дорноговь аймаг, Сайншанд сум

Сургалтын зардал гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.3.4 дэх заалтууд, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 85 дугаар тушаал, Газрын даргын 2019 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах"-ийн 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Лабораторийн шинжээч Баянжаргалын Дүүрэнжаргалыг хэмжлийн эргэлзээ тооцох сургалтанд хамрагдахад шаардагдах зардлыг гаргасугай.

2. Дээрх зардалд шаардагдах 90000 / ерэн мянга / төгрөгийг техник хяналтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
 ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЭНХБАТ



129

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 8/83

Дорноговь аймаг, Сайншанд сум

Зардал гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.3.4 дэх заалтууд, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 85 дугаар тушаал, Газрын даргын 2019 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах"-ийн 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор байгууллагад бичиг хэргийн хэрэгсэл худалдан авахад шаардагдах зардлыг гаргасугай.

2. Дээрх зардалд шаардагдах 845250 / найман зуун дөчин таван мянга хоёр зуун тавь / төгрөгийг техник хяналтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



[Signature] Х.ЭНХБАТ



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНЦЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/64

Дорноговь аймэг, Сайншанд сум

Зардал гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.3.4 дэх заалтууд, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 85 дугаар тушаал, Газрын даргын 2019 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах"-ийн 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор автомашинд сэлбэг, техник хэрэгсэл худалдан авахад шаардагдах зардлыг гаргасугай.

2. Дээрх зардалд шаардагдах 512500 / таван зуун арван хоёр мянга таван зуу / төгрөгийг техник хяналтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЭНХБАТ



131

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭЖҮҮЛГЭЧ АГЭГЭЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/05

Дорноговь аймаг, Сайншанда сум

Ажил хүлээлцүүлэх тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйл, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Хатанбулаг сумын газрын даамал Энхбаатарын Одчимэгт ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: А.Анхилдөл	/Газрын кадастр, газар өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн/
Гишүүн: Д.Сайнтуяа	/Ерөнхий нягтлан бодогч /
Б.Жавзанпагам	/Мэдээлэл, технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн/
Б.Батгэрэл	/ Нярав/

2. Э.Одчимэгийн ажлыг 2020 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн дотор хүлээлцэж дуусгахыг ажлын хэсгийн ахлагч / А.Анхилдөл /-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЭНХБАТ



ДОРНОГОвь АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 4/66

Дорноговь аймэг, Сайншанд сум

Тэтгэмж олгох тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.7 дахь заалт, Газрын даргын 2019 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах"-ийн 4.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Хот байгуулалтын кадастр, зураг төсөл, магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн Элбэгийн Нандинцэцэгийн гэр бүлд шинээр хүүхэд мэндэлсэнтэй холбогдуулан тэтгэмж олгосугай.

2. Дээрх тэтгэмжид шаардагдах 100 000 /нэг зуун мянга/ төгрөгийг Нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  ЦОЮУНСАЙХАН



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 4/62

Дорноговь аймэг, Сайншанд сум

Тэтгэмж олгох тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.7 дахь заалт, Газрын даргын 2019 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах"-ийн 4.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Албан хэрэг хөтлөлт, архивын асуудал хариуцсан мэргэжилтэн Гансугирын Ундармаагийн гэр бүлд шинээр хүүхэд мэндэлсэнтэй холбогдуулан тэтгэмж олгосугай.

2. Дээрх тэтгэмжид шаардагдах 100 000 /нэг зуун мянга/ төгрөгийг Нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ц.ОЮУНСАЙХАН



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЗЭГЛАГ

**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 0168

Дорноговь аймаг, Сайншанд сум

Ажил хүлээлцүүлэх тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйл, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Мандах сумын газрын даамал Гансүхийн Оюун-Эрдэнээс ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Оюунгэрэл	/Газрын удирдлагын хэлтсийн дарга /
Гишүүн: Х.Энхбат	/Геодези, зураг зүйн асуудал
	хариуцсан мэргэжилтэн /
Б.Жавзанпагам	/Мэдээлэл, технологийн асуудал
	хариуцсан мэргэжилтэн/
Б.Батгэрэл	/ Нярав/

2. Г.Оюун-Эрдэнийн ажлыг 2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн дотор хүлээлцэж дуусгахыг ажлын хэсгийн ахлагч / Н.Оюунгэрэл /-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОЮУНСАЙХАН



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 17/69

Дорноговь аймаг, Сайншанд сум

Сургалтын зардал гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.3.4 дэх заалтууд, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 85 дугаар тушаал, Газрын даргын 2019 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах"-ийн 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Лабораторийн шинжээч Баянжаргалын Дүүрэнжаргалыг ISO/IEC 17025:2018 сургалтанд хамрагдахад шаардагдах зардлыг гаргасугай.

2. Дээрх зардалд шаардагдах 90000 / ерэн мянга / төгрөгийг техник хяналтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ОЮУНСАЙХАН



156

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХАМГАЖУУЛГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 8/20

Дорноговь аймаг, Сайнтунцаг сум

Зардал гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.3.4 дэх заалтууд, Газрын даргын 2019 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах"-ийн 4.2 дахь заалт, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 85 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор барилгын материалын лабораторт тоног төхөөрөмж худалдан авахад шаардагдах зардлыг гаргасугай.

2. Дээрх зардалд шаардагдах 16500000 / арван зургаан сая таван зуун мянга / төгрөгийг техник хяналтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ц.ОЮУНСАЙХАН



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНЦЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

138
᠒᠐᠒᠐ оны 1᠑ сарын 3᠐ өдөр

Дугаар ᠑/᠓

Дорноговь аймаг, Сайнтүвшин сум

Г

Г

Зардал гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.3.4 дэх заалтууд, Газрын даргын 2019 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах"-ийн 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор байгууллагад компьютерийн техник хэрэгсэл / hard disk / худалдан авахад шаардагдах зардлыг гаргасугай.

2. Дээрх зардалд шаардагдах 1200000 / нэг сая хоёр зуун мянга / төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ц.ОЮУНСАЙХАН



138

ДӨРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭЖЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

Ард оон 11 сарын 30 өдөр

Дугаар 472

Дорноговь аймэг, Сайтманд сум

Зардал гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.3.4 дэх заалтууд, Газрын даргын 2019 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан "Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах"-ийн 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор байгууллагад өндөр хурдны скайнер худалдан авахад шаардагдах зардлыг гаргасугай.

2. Дээрх зардалд шаардагдах 8100000 / найман сая нэг зуун мянга / төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ц.ОЮУНСАЙХАН



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНЦЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/73

Дорноговь аймаг, Сайншанд сум

Зардал гаргах тухай

